



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/76

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Элэг шилжүүлэн суулгах хагалгаанд ороход эмчилгээний зардалд дэмжлэг хүссэн Мөрөн сумын ахмад настан Д.Дашгэндэнд 500,000 төгрөг, тэргэнцэр авахад санхүүгийн дэмжлэг хүссэн Мөрөн сумын ахмад настан иргэн Н.Цийрэгзэнд 500,000 төгрөг, Улаанбаатар хот руу онош тодруулах, эмчилгээ хийлгэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн Жаргалант сумын иргэн Ш.Оюунбаатарт (Хий үзэгдэлт дэмийрэл оноштой) 300.000 төгрөгний, эмчилгээний зардал хүссэн Мөрөн сумын иргэн Б.Батлхагвад (Тархины уйланхайтай оноштой) 300.000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх зардлын 1,600.000 (Нэг сая зургаан зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6717010344